

## **БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

#### **1.1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Өндөр их Алтайн оргил, Алтай Таван богд хайрханы Тэнгэрийг тайх ёслол 8 дугаар сарын 3-ны өдөр ёслол төгөлдөр боллоо. 2012 онд Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг буулгаж энэхүү хайрханыг тахиx тухай шийдвэр гаргаснаас хойш хоёр дахь удаа Төрийн тахилга үйлдсэн юм. Энэ удаагийн тахилгад УИХ-ын гишүүн, ЗГ-ын гишүүн, Барилга Хот Байгуулалтын сайд Х.Баделхан, УИХ-ын гишүүн Г.Солтан, Д.Мурат, С.Эрдэнэ, аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан, аймгийн Засаг дарга А.Гылымхан, Төрийн ёслолын хэлтсийн дарга Х.Жанцан, тэргүүтэй төрийн элч төлөөлөгчид болон гадаад, дотоодын зочид нутгийн зон олон оролцов.

“Төрийн болон байгууллагын архивын хөгжил, төлөвшил” сэдэвт танилцуулга, үзүүлэх сургууль 2019 оны 8 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдсан ба уг сургалтад Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар болон Архивын тасгийн удирдлага, мэргэжилтнүүд оролцож туршлага солилцов.

2019-2020 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотой аймгийн багш нарын бага хурал болж өнгөрөв. Тус хуралдаанд Баян-Өлгий аймгийн Засаг дарга оролцож нийт багш, ажилчдад сурлагын өндөр амжилт хүсэж, ирж буй хичээлийн шинэ жилд улам их амжилт гаргаж аймгийн боловсролын салбарт үнэтэй хувь нэмэр оруулж ажиллахыг үүрэг болгов.

Засгийн газрын "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хөтлөлт"-ийн улсын үзлэг явуулах тухай 2019 оны 150 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хөтлөлтийн улсын үзлэгийн ажлын хэсэг тус аймагт ажиллаж байна.

### **ХОЁР. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

#### **2.1. Эрүүл мэндийн чиглэлээр**

Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад болон аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт А хепатитаас урьдчилан сэргийлэх талаар албан даалгавар, зөвлөмж явуулсан.

“Хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг дэмжих Дэлхийн долоо хоног”-ийг “Энхрий үрс эрүүл торниход Эцэг хүний үүрэг чухал” уриан дор 2019 оны 8 дугаар сарын 1-7-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, орон нутгийн радиогоор болон “Дербес” телевизээр ярилцлага өгч, “Энхрий үрс эрүүл торниход эцэг хүний үүрэг чухал” сэдэвт ТВ шторкийг “Дербес”, “Саян” телевизээр болон цахим хуудсаар олон нийтэд сурталчилж түгээсэн ба 593 жирэмсэн эмэгтэй болон хөхүүл ээж, 116 эмч эмнэлгийн ажилчид, 55 аж ахуйн нэгжийн ажилчид, 314 аав сургалтад хамрагдсан.

Эрүүл мэндийн газар болон 4 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулагдсан Элэгний В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын үйл ажиллагаанд 40 иргэн хамрагдсан.

Эрүүл мэндийн ажилтны өдрийг тохиолдуулан нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг Засгийн газрын болон эрүүл мэндийн яамны шагналаар шагнаан урамшуулсан.

“Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын 4-р судалгаа”-г Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн газартай хамтран 7 дугаар сарын 21-нээс 8 дугаар сарын 1-ний өдрүүдэд Өлгий сумын 4, 8, 11 дүгээр баг, Дэлүүн сумын Хөхтолгой, Ногооннуур сумын Цагааннуур баг, Толбо сумын Бураат баг, Цэнгэл сумын Цагаан түнгэ баг, Алтанцөгц сумын Хаш баг, Баяннуур сумын Цул улаан багуудад 15-69 насны 162 иргэнийг судалгаанд хамруулан ажилласан. Судалгааны үр дүн тодорхой төлөвлөгдсөн хугацааны дараа гарах болно.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны хэрэгжилтийн хүрээнд ДЭМБ, НҮБ ХАС, Оном сан, ХӨСҮТ, ЭМДЕГ-аас 7 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд болон Толбо сумын Эрүүл мэндийн төвүүдэд хяналт-үнэлгээ хийж ажилласан.

### **Зоонозын өвчин судлалын төвийн (ЗӨСТ) ажлын талаар**

2019 оны 7-р сарын 20-ноос 8-р сарын 20-ныг хүртэл Улаанхус, Ногооннуур сумдын Монгол-ОХУ-ын хил дагуух голомтуудад хийгдсэн тарваган тахлын байгалийн голомт хяналтын хамтарсан тандалт шинжилгээгээр 223 мэрэгч амьтан, 174 мэрэгчийн зэм үхдэл, 15 махчин шувууны гулгидас, 312 гаднын шимэгч, нийт 724 нэгж материал дээжлэн лабораторид хурдавчилсан сорил, нян, ийлдэс судлал, молекул биологи, биологийн аргаар шинжилгээ хийхэд хурдавчилсан сорилоор 19 материалд тарваган тахлын нянгийн эсрэгтөрөгч эерэг тодорхойлогдож, нян судлалаар 30 тарваган тахлын нян илрүүлэн, ийлдэс судлалаар 3 мэрэгч амьтанд тарваган тахлын эсрэг бие эерэг, 2 мэрэгч ба 35 мэрэгчийн зэм үхдэлд нийт 40 материалд тарваган тахлын эсрэгтөрөгч эерэг тодорхойлогдож, молекул биологийн аргаар шинжлэхэд 49 материалд тарваган тахлын үүсгэгчийн ДНХ илэрч, үүнийг зохих журмын дагуу савлан, холбогдох дагалдах бичгийг бүрдүүлэн, тахлын үүсгэгч агуулсан байж болзошгүй сэжигтэй 5 мэрэгчийн зэм үхдэлийн сорьцын хамт цаашид судлуулахаар ЗӨСҮТөвд хүргүүлэхээр тус төвөөс хамтарсан тандалтад ажилласан багийн бүрэлдэхүүнд хүлээлгэн өгсөн.

Хамтарсан тандалт шинжилгээний багийн 2017-2019 оны 3 жилийн ажлын үр дүнг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулсан.

Баян-Өлгий аймгийн ЗӨСТөв, ОХУ Эрхүү хот дахь Сибирь Дорнодын ТТЭМЭШХ, Алтайн ТТЭССтанц багууд хамтран Сийлхэмийн нурууны улсын хил дагуух 12 голомт газруудад тарваган тахлын тандалт судалгаа хийж, 35 тарваган тахлын нян үүсгэгч илэрч тарваган тахлын байгалийн голомт өндөр идэвхтэй байгаа нь тогтоогдсон.

2019 оны 4 дүгээр сард Баян-Өлгий аймгийн Ногооннуур суманд тарваган тахлын хүний өвчлөл гарсантай холбогдуулан 2020 онд Ногооннуур сумын нутаг улсын хил дагуух голомт идэвхтэй байгаа Хаг нуур, Жаргалантын голомтуудын эпизоотын чиглэлийг угтуулан шимэгчгүйтгэлийн ажлыг эпизоотын идэвхийг бууруулах ажлын төлөвлөгөө боловсруулж аймгийн Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан ажиллаж байна.

ОХУ-ын Эрхүү хотын Сибирь Алс Дорнодын тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэн болон Монгол улсын ЭМЯ-ны харьяа Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төвийн хооронд байгуулсан “Монгол Улс, ОХУ-ын хил орчмын бүс дэх тарваган тахлын байгалийн голомтын орчин үеийн байдал”/2017-2021 он/ сэдэвт эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны гэрээний дагуу Баян-Өлгий аймгийн Монгол Алтай Нурууны Улсын тусгай хамгаалалттай Силхэмийн нурууны улсын хил дагуух газарт хийсэн 3 жилийн хамтарсан шинжилгээний үр дүн болон тарваган тахлын голомтын эпизоотын талаар ард иргэдэд чиглэсэн мэдээ мэдээллийг 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Монголын орон нутгийн радиод болон “МОНЦАМЭ” агентлагт өгч ажилласан.

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

### 3.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

2019 оны 8 дугаар сарын 3-нд болсон Алтайн Таван Богд уулын тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолын арга хэмжээнд Алтай Таван Богдын ууланд Эко ОО, зөөврийн хогийн сав байгуулах ажлыг хийж гүйцэтгэв.

2020 онд байгалийн баялгаас орох орлогын саналыг гаргаж аймгийн Татварын хэлтэст хүргүүлэн, байгууллагын 2020 оны төсвийн төслийг Сангийн яамны цахим програмд орууллаа.

5 аж ахуйн нэгжийн төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж хүргүүлэв.

БОАЖЯамны Төрийн нарийн бичгийн даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу Булган сумын “Улаагчин”, Дэлүүн сумын “Улаан говь”, Баяннуур сумын “Уушгийн улаан”, Алтанцөгц сумын “Мундуйн дэвсэг”, Толбо сумын “Зурхайчийн нуруу”, Алтай сумын “Халуун барам”, Сагсай сумын “Ар бөхөн”, Цэнгэл сумын “Бор бургасан” Ногооннуур сумын “Модон овоо”, “Бураат”, Улаанхус сумын “Хүрэн уул”, “Баянзүрх”, Бугат сумын “Төмөрт” агнуурын бүс нутгуудад агнуур судлалын нийгэмлэг төрийн бус байгууллагатай хамтран хяналтын үнэлгээ хийх ажлыг зохион байгууллаа.

Баян-Өлгий аймгийн 2020 оны Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой суурь зардлыг тооцоход ашиглах үр дүнгийн үзүүлэлтийг гаргаж, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэв.

Аймгийн төвийн болон сумдын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд өөрсдийн эзэмшлийн газрын хог хаягдлаа цэвэрлэх албан шаардлага хүргүүлж, аймгийн төвийн 15 км тойрогт, сумдад 8 км тойрогт, баг, хот, айлд 5 км-ийн тойрогт орших гол мөрөн, нуур цөөрөм, булаг шанд, уст цэгийг ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэх, байгалийн голдиролыг сэргээх, тохижуулах, хамгаалах арга хэмжээнд нийт 1200-гаад иргэдийг оролцуулан 17 гол, 2 нуур, 20 булаг шанд, 3 рашааны эхийг цэвэрлэн 35 тонн ил задгай дур мэдэн асгасан эзэнгүй, хуурай хог хаягдал, малын үхсэн сэг зэмийг ачиж төвлөрсөн хогийн цэгт хүргэх ажлыг зохион байгууллаа.

Хог хаягдлын тухай хуулийг сурталчлах тараах материал хийж, сурталчилгааны ажил зохион байгуулав.

Орон нутгийн хэвлэл мэдээллээр Хог хаягдлын тухай хуулийг бүс нутгийн хэмжээнд бүх түвшинд сурталчлах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, үүсгэгч нь

хариуцах, бохирдуулагч нь төлөх, урамшууллын шинэ системийг хэрэгжүүлж хэвшүүлэх, зөрчилд хариуцлага тооцох талаар, сар бүр тухайлсан сэдвийн хүрээнд уралдаан зарлаж, олон нийтэд сурталчлан таниулах зорилготой БОАЖЯамнаас зохион байгуулж буй “Хандлагаа өөрчилье” багц ажлын хүрээнд “ХОГГҮЙ ЦЭВЭРХЭН МОНГОЛ” аяны тухай мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулж байна.

### **3.2. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр**

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын ХХ.1.43-д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 10 иргэний 6559м<sup>2</sup> газрыг өмчлүүлсэн болно.

Аймгийн хэмжээнд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших, ашиглах гэрээг дүгнэх, шинэчлэх ажлын хүрээнд удирдамж боловсруулан батлуулж уг ажлыг эхлүүлээд байна.

2019 оны төлөвлөгөөний дагуу 12 сумын бэлчээрийн даацыг фото-мониторингийн аргаар тодорхойлон шатахууны зардлын 80 хувийг аймгийн “Бэлчээр ашиглалтын холбоо, “Малчин төв”-өөр дамжуулан шийдвэрлүүлж өгсөн.

9 сумын бэлчээрийн газарт бэлчээрийн даацыг фото-мониторингийн аргаар тодорхойлсон ажлын үр дүнг “Sample point” програм дээр боловсруулсан ажлыг хүлээж авсан.

Аймгийн төв талбайд баригдах Монгол улсын баатар М.Икейн хөшөөний байршлыг аймгийн Засаг даргын шийдвэрээр шинэчлэн тогтоож координатжуулан гүйцэтгэгч байгууллагад хүлээлгэн өгсөн.

Барилгын тухай хуулийг дагалдан гарсан 10 гаруй дүрэм журмыг Баян-Өлгий аймагт хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай тайланг гаргаж, нотлох баримтын хамт БХБЯаманд хүргүүлсэн.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн бусдад шилжүүлэхийг хүссэн 3 иргэний хүсэлтийг холбогдох материалын хамт хүлээн авч Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан ЗДТГ-т хүргүүлэв. “Өлгий-ланд”, “Эл эм ланд” ХХК-ийн хийсэн 126 газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч кадастрын мэдээллийн санд оруулсан болно.

### **3.3. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр**

Төвийн вэб сайтад холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан, Даваа гариг бүр ажилчдын шуурхай хурлыг тогтмол зохион явуулж байна.

8 дугаар сард байгууллагаас 9 ш албан тоот боловсруулан гаргасан.

Цаг агаарын урьдчилсан мэдээний талаар аймгийн радио болон орон нутгийн телевизэд ярилцлага өгч, 9 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээг холбогдох газруудад болон сумын өртөө, харуулуудад цахим хэлбэрээр хүргүүлэв.

2019 оны 8 дугаар сарын 23-наас 28-ний өдрүүдэд Алтай Таван богд ууланд Ус, цаг уурын баруун бүсийн сургалтыг амжилттай зохион байгуулав. Сургалтад УЦУОШГазрын дарга, УЦУОСМХүрээлэнгийн Гадаргын усны секторын эрхлэгч, Говь-Алтай, Ховд, Увс аймгийн төлөөлөгч нар оролцов.

## ДӨРӨВ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

**1. АЛТАЙ СУМ****Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар**

Аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн Өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах тухай А/578 дугаар захирамжийг хүлээн авч сумын Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл хангуулах тухай А/112 дугаар захирамж гарсан ба бүх иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд өвлийн бэлтгэл ажлыг хангах тухай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах арга хэмжээнүүд зохиогдож байна.

Мөн аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн А/569 дүгээр захирамжаар төрийн албан хаагчдын зэрэг дэвийг шинээр тогтоох буюу ахиулан тогтоох тухай гаргасан шийдвэрийг холбогдох албан тушаалтнуудад танилцуулав.

Сумын Аюулгүйн фондод өвс тэжээл бэлтгэх зорилгоор Хилийн цэргийн 0165 дугаар ангийн захирагч болон Шарговийн 0147 дугаар Заставын дарга нарт хүсэлт гаргаж өвс бэлтгүүлэхээр Шархамар хэмээх газар очих зөвшөөрөл авах бэлтгэлээ ханган ажиллаж байна.

8 дугаар сард Ажлын хэсэг байгуулах тухай 2, өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах тухай, газар эзэмшүүлэх захирамжид өөрчлөлт оруулах тухай мөн ажлын хэсэг байгуулах тухай захирамж гаргаж биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Мөн сумын ЗДТГ-ын даргаас зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай болон ээлжийн амралт олгох тухай 2 тушаал гарч биелэлтийг хангуулан ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын даргаас 3 албан тоот, Засаг даргаас 8 албан тоот явуулсан ба бүртгэлийн дэвтэр хөтөлж боловсруулсан, нийлсэн, хянасан стандартыг мөрдөн ажиллаж байна.

**Хоёр. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар**

Иргэний 12 төрлийн бүртгэлийг хөтлөн явуулж зохих хууль, журмын дагуу гэрчилгээ олгож байна. 8 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар шинээр төрсөн 9 хүүхдэд төрсний гэрчилгээ олгож, шинээр гэрлэсэн 2 хосыг гэрлэлтийн бүртгэлд бүртгэж, нас барсан 4 иргэний нас барсны үнэмлэх олгож цахим үнэмлэхийг хүчингүй болгуулав.

Шинээр иргэний үнэмлэх авах 7 иргэнийг мөн 25, 45 насны сунгалт хийлгэх нийт 5 иргэнийг шинэчилсэн бүртгэлд хамруулав. Иргэдийн гарт 18 цахим үнэмлэх олгож ИУБ-21 маягт бичиж мэдээллийн санд оруулав. ИГББ-н бүртгэлийн мэдээг ажлын 5 хоногт 2 удаа аймгийн УБХ-т, тухайн сарын 25-ны мэдээг сумын ЗДТГ-т тайланг өгч ажиллав.

Нэрийн санд хаяг тусгах 32 хүүхдийн судалгааг нотлох баримт бүхий жагсаалтын хамт УБЕГ-т тогтоосон маягтаар хүргүүлж хаяг тусгуулав.

**Гурав. Хөдөө аж ахуйн талаар**

Хөдөөгийн малчин иргэд өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураах, өвс тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулж байна. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2008 оны 78 тоот тушаал болон аймгийн Засаг даргын 2019 оны А/226 тоот тушаал, мөн сумын Засаг даргын 2019 оны А/55 тоот захирамж, 2019 оны А/578 тоот захирамжуудыг хэрэгжүүлэх зорилгоор сумын хэмжээний өвс, тэжээл бэлтгэх, өвлийн бэлтгэл ажил хангуулах талаар багийн Засаг дарга нар болон иргэд, малчдад ойлголт өгч захирамжийг танилцуулан ажиллав.

Тус сумын газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 1 га газарт төмс, 3 га газарт хүнсний ногоо, 15 га газарт ногоон тэжээл, 0,2 га газарт чацаргана тус тус тариалсан ба түүнийг усжуулан тордож ургуулах арга хэмжээнүүдийг авч ажиллав.

Хашиж хамгаалсан хадлангийн талбайн судалгааг багийн Засаг дарга нараас авч нэгтгэн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүр

гүүлэн ажиллав. Тус оны байдлаар сумын хэмжээнд 139 га газрыг хашиж хамгаалан хадлан авч байна.

Улсын хөрөнгө оруулалтаар 170,0 сая төгрөгийн хөрөнгөөр 100 га талбайд услалтын систем барьж байгуулсан ба тус сард дутуу үлдсэн ажлуудыг хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.

### **Дөрөв. Байгаль орчны хяналтын үйл ажиллагааны талаар**

Зөвшөөрөгдөөгүй газруудад хаягдсан хог хаягдал, малын сэг зэмийг цэвэрлүүлэх ажлыг Хөдөө аж ахуйн тасагтай хамтран гүйцэтгэж, нүх ухуулан ариутгал хийж булуулав.

Энэ сард аргалын тооллогыг хийхэд Халуунд 53 аргаль, угалз, 6 хурга, Шарговьд 17, Даваатад 18, Цалгарт 8 аргаль 4 угалз нутагшин зусаж байгаа болно. Яамнаас зөвшөөрөлтэй компанитай хийгдсэн гэрээний дагуу ан агнуулах ажлыг 8 дугаар сард хийхээр төлөвлөн ажиллаж байна.

### **Тав. Газар зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар**

Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.

Шинээр газар эзэмшүүлэх хүсэлт гаргасан 4 өргөдөл, газрын маргаантай 1 иргэний өргөдөл,  $\vec{a} \cdot \vec{b} = |\vec{a}| |\vec{b}| \cos \alpha$  тус тус  $\vec{a} \cdot \vec{a} = |\vec{a}|^2$  бүртгэж, өвөлжөө, хаваржааны зориулалтаар 3 иргэний эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх сумын Засаг даргын захирамжийг үндэслэн газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгов.

Тус сард 11 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 программд оруулан цахимд архивлав.

### **Зургаа. Боловсролын үйл ажиллагааны талаар**

Сургуулийн сургалтын шинэ корпус их засвар хийж хичээлийг эхлэхэд бэлэн болгов. Мөн сургуулийн ойр орчны болон дотуур байрны бүх обьектод цэвэрлэгээ, засвар хийж, анги танхимуудыг будаж хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас хамтран зохион байгуулсан сургалт семинарт бүх багш нарыг бүрэн хамруулсан.

Сургуулийн түүхт 60 жилийн ойн арга хэмжээг 2019 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

### **Долоо. Эрүүл мэндийн чиглэлээр**

Жирэмсний хяналтад шинээр 5 эхийг авсан ба одоо хяналтад 51 эх байна. Мөн өртөмтгий эмзэг бүлгийн жирэмсэн эхийн тоо 11 байна. Эрүүл мэндийн төвийн ажил хэвийн явагдаж байна.

## **2. БУЛГАН СУМ**

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалт, хууль эрх зүйн талаар**

Энэ сард ихэнх төрийн албан хаагчид ээлжийн амралттай байв. 2019 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх томоохон ажлуудын нэг болох сумын төвийн хатуу хучилттай авто замын ажлын тендерийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас зарласан. Уг тендерт шалгарсан компани нь зураг төсвийн дагуу замын ажлаа хугацаандаа эхлүүлээд байна. Мөн сумын Засаг даргын өвөлжилтийн бэлтгэл хангах тухай захирамжийн дагуу бүх төсөвт байгууллагуудад хяналт тавьж ажиллаж байна.

### **Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

Сумын санхүүгийн албаны ажил хэвийн явагдаж, 8 дугаар сарын бүх төсөвт байгууллагуудын санхүүжилт хийгдэж, цалин хөлсийг зохих журмын дагуу олгож байгаа болно. Бүх нягтлан бодогчид хагас жилийн санхүүгийн тайлан болон 2020 оны төсвийн төлөвлөгөөг аймагт тушаасан.

### **Гурав. Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд**

8 дугаар сард иргэд багийн ИНХурлаас тогтоосон хугацааны дагуу уулын болон голын хадландаа орсон. Одоогийн байдлаар малчид нийт 4050 тн хадлан бэлтгэж авсан мэдээтэй байна. Байгаль орчны тухай хууль зөрчсөн ямар нэгэн асуудал гараагүй ба гадаадын анчдаар ан агнуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Байгаль хамгаалагч нар иргэдийн өвлийн түлээ мод бэлтгэх ажилд хяналт тавьж ажиллаж байна.

### **Дөрөв. Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн бодлогын хүрээнд**

Тус сумын үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн ажил хэвийн явагдаж байна. Цахилгаан эрчим хүч тасалдаагүй хэвийн ажилласан. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх, авто зам, засварын болон дэд бүтцийн чиглэлийн ажлууд хугацаандаа хийгдэж байна. Сумын төвийн авто зам тавих ажлын тендер нь зарлагдаж, тендерт шалгарсан компани нь замын ажлаа хийж эхлүүлээд байна.

### **Тав. Боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар**

Сумын 3 сургууль, 2 хүүхдийн цэцэрлэгийн бүх ажилтнууд 9 дүгээр сарын 1-нээс Шинэ хичээлийн жилийн нээлтийн ажлаа хийхээр төлөвлөн ажиллаж байна. Сумын сургууль, цэцэрлэгүүд болон сурагчдын эрэгтэй, эмэгтэй дотуур байранд урсгал засвар хийхээс гадна өвөлжилтийн бэлтгэл ажил болох нүүрс, түлээгээ бэлтгэж байна. 2019 оны 8 дугаар сарын 20-24-ний хооронд бүх багш нар аймагт болсон сургалтад хамрагдаж ирсэн.

### **Зургаа. Эрүүл мэнд, спортын талаар**

Тус сумын эрүүл мэндийн төвд тухайн сард 10 эх амаржиж, 10 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. 10 эхийн төрөхийн ор хоног 47 ор хоног байна. Хяналтад 69 эх байгаа ба нас баралт тухайн сард гараагүй. Эрүүл мэндийн төвд нийт 62 хүн хэвтэн эмчлүүлсний ор хоног 371 ор хоног байна. Түргэн тусламжийн дуудлага 86 гарснаас 78 нь алсын дуудлага байв. Бүх үзлэг 749 байснаас урьдчилан сэргийлэх үзлэгт 163, амбулаторын үзлэгт 427 хүн тус тус хамрагдсан. Вакцинжуулалтад 46 хүүхэд хамрагдсан.

### **3. УЛААНХУС СУМ**

#### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Ерөнхийлөгчийн төрийн тахилгатай холбоотой Тамгын газрын нийт албан хаагчдад хурал хийж, тахилгын бэлтгэл ажлыг хангах, нийт албан хаагчид тахилгын үеэр Алтайн Таван богдод очиж ажиллах талаар Сумын Засаг дарга үүрэг даалгавар өгч, ажиллав.

Тахилгын бэлтгэл ажлын хүрээнд 7 дугаар сарын 31-ний өдрөөс 8 дугаар сарын 3-ны өдөр хүртэл Сумын удирдлагууд, Тамгын газрын нийт албан хаагчид, багийн Засаг дарга нар Таван богдод очиж 3 эсгий гэр барьж, доторх чимэглэл, ор, хөнжил, ширээ сандлаар хангаж гадаад дотоодоос ирсэн зочдыг хүлээн авч, үйлчилгээ үзүүлж ажилласан болно. Мөн сумын 1, 2, 11 дүгээр багуудад төрийн тахилгыг холбогдуулан “Бэсрэг наадам” зохион байгуулсан.

8 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн ээлжийн амралтаа эдлээгүй төрийн албан хаагчдын хүсэлтийн дагуу амралтыг нь олгов.

Аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах А\578 тоот захирамжийн дагуу Сумын Засаг даргаас 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдөр А\129 дүгээр захирамж гарсан ба сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байна.

Энэ сард сумын Засаг даргаас нийт 6 захирамж гарсан ба Засаг даргын Тамгын газрын даргаас тушаал гараагүй.

Архив , бичиг хэргийн стандартыг хангуулан ажиллаж, явсан бичгийн бүртгэлийг хөтлүүлэх, хариутай бичгийн хариуг тогтмол хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2019 оны 8 дугаар сард Тамгын газарт бусад газраас 5 бичиг ирсэн. Үүнээс 2 хариутай, 3 бичиг хариугүй бичиг байна. Хариутай бичгийн хариуг цаг тухайд нь холбогдох албан тушаалтнаар гаргуулан зохих газарт явуулж байна. Тамгын газраас бусад газарт 11 бичиг явуулав. Иргэдээс 4 өргөдөл хүлээн авч, Засаг даргад танилцуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлэн хариуг эзэнд нь мэдэгдэж байв.

#### **Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

Төсөвт байгууллагуудын төсвийг батлагдсан төсвийн багц, Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д заасан төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлж хамрах хүрээ, зарчим харилцааг зохицуулж ажиллаа. 2019 оны бүх төсөвт байгууллагуудын хагас жилийн нэгтгэл тайлан гаргаж хугацаанд зохих газарт нь хүргүүлсэн. Мөн төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээг тухай бүр явуулж байна.

Байгууллагуудын батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг байгууллага бүрээр, эдийн засгийн ангиллаар шилжүүлж байна.

Төлбөр тооцоог анхан шатны баримтад тулган хянаж шилжүүлэг хийлгэж, төрийн сангийн заавар журмын дагуу байгууллагуудын төлбөрийн хүсэлтийг архив үүсгэн хадгалж байна. 2019 оны 8 дугаар сарын 1-28-ны хооронд 92,465,665 төгрөгийн 65 гүйлгээ хийсэн болно.

Байшин орон сууцны тооллогын ажлын хүрээнд сумын 11 багт түр товчоо байгуулан ажилласан. Тооллоготой холбоотой зохион байгуулсан сургалтад төрийн



сангийн мэргэжилтэн болон 3 тоологчийг хамруулсан. Тооллогыг хугацаанд амжилттай зохион байгуулсан ба нийт 1708 байшин, орон сууц тоологдсон.

### **Гурав. Хүүхдийн цэцэрлэгийн талаар**

Сумын төвийн хүүхдийн цэцэрлэгийн ажил зууны цэцэрлэгт шилжин, сумын төвд үйл ажиллагааг явуулсан. Сумын алслагдсан Даян, Баянзүрх багуудад хувилбарт гэр цэцэрлэгийг ажиллуулж үйл ажиллагааг явуулсан ба нийт 80 гаруй хүүхэд хамрагдсан. Сумын төв цэцэрлэгт их засвар хийгдэж, бүх багш, ажилчид анги танхимаа янзалж хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Сумын Засаг даргын Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай захирамжийн дагуу 1 сая төгрөгөөр цэцэрлэгийн гадна, дотор талын урсгал засварыг хийж гүйцэтгэсэн. Төвлөрсөн бус халаалтын эх үүсвэрээр халдаг цэцэрлэгийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 6 тонн нүүрс, 5 куб.метр мод бэлтгэсэн. Байгууллагын ажилчдыг 4 төрлийн шинжилгээнд хамруулж, шинжилгээний хариуг гаргуулсан.

Аймгийн “Хос ханат”, “Хызыл өрик” ХХК-тай гэрээ байгуулж хүнсний нэг сарын нөөцийг бүрдүүлсэн болно.

### **Дөрөв. Хөдөө аж ахуйн талаар**

Аймгийн Засаг даргын 2019 оны Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай захирамж гарч, хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах төлөвлөгөө хавсралтаар батлуулан ажиллаж байна. Энэ жил аймгийн Засаг даргын захирамжаар 3700 тн өвс бэлтгэх төлөвлөгөө өгөгдсөнөөс одоогийн байдлаар 3000 тн өвс бэлэн байгаа. Ноосны урамшуулалд хамрагдах нийт 381 малчны падааныг хүлээн авч, хянан программд бичилт хийж, 60 тн ноосыг аймагт тушаасан.

Хилийн зурваст отор нүүдэл хийх өрх, малын судалгааг гаргаж, аймгийн Хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Хийлийн зурвас бүс нутагт нийт 135 өрхийн 33530 толгой мал өвөлжих төлөвлөгөөтэй байна. Үүнээс улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 101 өрхийн 25120 толгой мал өвөлжихөөр байна.

## **4. ЦАГААННУУР ТОСГОН**

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Аймгийн Засаг даргын 2019 оны А/578 тоот “Өвөлжилтийн бэлтгэл хангуулах тухай” захирамжийн дагуу тосгоны хэмжээнд өвөлжилтийн бэлтгэлийн төлөвлөгөө гаргаж, бэлтгэл хангуулах ажлын хэсгийг тосгоны захирагчийн 2019 оны А/38 тоот захирамжаар томилон ажиллуулав.

Байгууллага бүр өвөлжилтийн бэлтгэлээ базаан дулаалга, засвар хийж байна.

Байшин орон сууцны 2019 оны тооллогыг 8 дугаар сарын 5-нд дуусгаж нийтдээ 344 байшин, 11 гэр, 43 нийтийн орон сууцыг тоолсон.

Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний судалгаа, гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоо мэдээг маягтын дагуу гаргаж аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт мэйлээр явуулав.

### **Хоёр. Хөдөө аж ахуйн талаар**

Хөдөөгийн малчид болон тосгоны төвд оршин суудаг мал бүхий иргэдэд дуудлагаар мал эмнэлгийн үйлчилгээг байнга үзүүлж байна.

Мал амьтны гоц халдварт буюу халдварт өвчин гараагүй, 2400 толгой малд паразит өвчний эсрэг ивомекийн тарилга хийгдсэн.

### **Гурав. Боловсрол, соёлын талаар**

Тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн байрны засварыг хийж дуусгав.

8 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд бүх багш нар болон удирдах ажилтнууд “Сайжруулсан хөтөлбөр”-ийн сургалтад хамрагдав.

Цэцэрлэгийн эрүүл ахуйг хангаж, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг хуваарийн дагуу тогтмол хийлгэж, хяналт тавьж ажилласан.

### **Дөрөв. Эрүүл мэндийн талаар**

Эрүүл мэндийн төв нь жирэмсэн болон өртөмтгий бүлгийн эхчүүдийг тогтмол хяналтад авч аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх тасгийн нарийн мэргэжлийн эмчид шилжүүлэн ажиллаж байна. Товлолын дагуу 0-2 насны хүүхдийг дархлаажуулалтад тогтмол хамруулж байна.

Өдрийн эмчилгээ болон хөнгөлөлттэй эмийн үйлчилгээнд ард иргэдийг хамруулан тасралтгүй үйлчилгээ үзүүлж байна.

Эрүүл мэндийн төвийн бүх ажилчдад “Яаралтай тусламж”-ийн талаар сургалт явуулав.

“Хүүхдийн эхийн сүүгээр хооллолтыг дэмжих дэлхийн долоо хоног”-ийг тохиолдуулан тосгоны залуу ээж, эмэгтэйчүүдэд сургалт сурталчилгаа зохион явуулав. Үүнд: Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих чиглэлээр батлагдан гарсан эрх зүйн баримт бичгүүдийг сурталчлан таниулав.

Статистик мэдээллийн талаар:

Бүх үзлэг	-	349
Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг	-	71
Амбулаторийн үзлэг	-	128
Гэрийн дуудлагын тоо	-	27
Алсын дуудлага	-	14
Нас баралт	-	1
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн	-	9 хүн
Эмнэлгээс эмчлүүлж гарсан	-	13 хүн
Өдрийн эмчилгээнд хамрагдсан	-	8 хүн
Аймагт төрсөн эх	-	2
Өөрийн эмнэлэгт төрсөн	-	0
Аймагт шилжүүлсэн жирэмсэн эх	-	3
Хяналтад байгаа жирэмсэн эх	-	29
Үүнээс: Шинээр хяналтад авсан жирэмсэн эх	-	4
Дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд	-	20

**Тав. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар**

Нийгмийн халамж, үйлчилгээнээс авах тэтгэвэр, тэтгэмжүүдийг олгож, 2 ахмад настанд нүдний болорын үнийн хөнгөлөлт, 1 ахмад настанд замын зардлын хөнгөлөлтийг олгов. Цалинтай ээж хөтөлбөрт 2 эхийг хамруулж, жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхийн нөхцөлт мөнгөн тэтгэмжид 5 эхийн материалыг хүргүүлэв.

**Зургаа.Нийгмийн даатгалын талаар**

Цагааннуур дахь Нийгмийн даатгалын ажил хэвийн явагдаж байгаа ба 4 хүнд жирэмсний амаржсаны тэтгэмж, 1 хүнд оршуулгын тэтгэмж олгосон.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР